

**ЭКСПЕРТҮҮДИЙН ТОМИЛГООНЫ ХЯНАЛТЫН ХУУДАС 1093
МАГАДЛАЛЫН ГЭРЭЭНИЙ ДУГААР ИГД-2022/1093**

Экспертүүд нь зураг төслийн ажилд магадлал хийхдээ, Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйл, Засгийн газрын 2019.03.21-ны өдрийн 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгы байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 5 дугаар зүйлийг үндэслэн дүгнэлт гаргана.

Зураг төслийн гүйцэтгэгч байгууллага: "Энх-Өрнөлт " ХХК

Объектын нэр, байршил: Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай замтай Хөшөөтийн уурхайг холбох авто замын зураг төсөлд зориулсан трассын дагуух инженер-геологийн судалгааны тайлан (Ховд аймаг - Дарви сум, Хөшөөт баг

№	Зураг төслийн бүрэлдэхүүн	Зураг төслийн гүйцэтгэгч	Зураг төсөлд магадлал хийх экспертийн		Магадлал хийгдсэн зураг төслийн хяналтын хугацаа					
			Нэр	Гарын үсэг	Эксперт зураг хянах хугацаа /Хуанлийн 6 хоногт/		Зураг төслийн байгууллага засварлах хугацаа /Хуанлийн 10 хоногт/		Тайлбар	
					Зураг төслийг хүлээн авсан он.сар.өдөр.цаг.мин	Эксперт тухайн зураг төсөлд магадлал хийж захиалагчид хүлээлгэн өгсөн он.сар.өдөр.цаг.мин	Экспертүүд гаргасан дүгнэлтийнхээ дагуу хянаж баталгаажуулсан он.сар.өдөр	Зураг төсөлд засвар хийгдсэн хугацаа		Магадлал хийгдсэн зураг төслөө ЗТМХ-т хүлээлгэн өгсөн
1	2	3	4	5	6	7	8	9	10	
1	Инженер геологи:	"Энх-Өрнөлт " ХХК	Г.Тунгалаг	99081348						

Барилгын хөгжлийн төвийн захирлын тоот тушаалаар баталсан зураг төслийн байгууллага болон магадлал хийх иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний хариуцлагаас Зураг төслийн байгууллага: 6.3. Зураг төсөл магадлалын ажлыг гүйцэтгэх гэрээний хугацаа хэтэрсэн хоног тутамд зураг төслийн магадлалын ажлын төлбөрийн дүнгийн 0.4 хувиар алданги тооцно.

Орон тооны бус эксперт: 4.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол дараах арга хэмжээг дэс дараалан тооцно. Үүнд

- Тухайн гүйцэтгэсэн ажлын магадлалын хөлсийг олгохгүй;
- Магадлал хийх эрхийг 6 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх;
- Магадлал хийх эрхийг гэрээний хугацаанаас өмнө цуцлах;
- Магадлал хийх эрхийг хүчингүй болгох;

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 325 тоот тогтоолоор Зураг төслийн баримт бичигт магадлал хийх хугацаа нийт 21 хоног байна. /Хугацааг хуанлийн хоногоор тооцно./

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалаар батлагдсан Барилгын төсөв зохиох дүрэм /БНБД 81-95-12/-ээр зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлын төлбөрийг зураг төсөл, инженер хайгуулын ажлын үнийн дүнгээс хувь тооцон авна./


Магадлалын хэлтэс-н мэргэжилтэн /Г.Чинзориг/

(Handwritten signatures and initials)

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ
ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР Инженер геологийн дүгнэлт

Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай замтай Хөшөөтийн уурхайг холбох авто замын зураг төсөлд зориулсан трассын дагуух инженер-геологийн судалгааны тайлан

2022 оны 06 сарын 02 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Объектын байршил	Ховд аймаг, Дарви сум, Хөшөөт баг
2	Объектийн нэр, хүчин чадал	Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай замтай Хөшөөтийн уурхайг холбох авто замын зураг төсөлд зориулсан трассын дагуух инженер-геологийн судалгааны тайлан
3	Тайлан дүгнэлтийн архив дугаар	№22-035
4	Захиалагч	"Аварга зам" ХХК
5	Хайгуул, судалгааны ажил гүйцэтгэх даалгавар	29км автозам
6	Судалгааны ажил гүйцэтгэх дэвсгэр зураг	M1:4000
7	Байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд	өгсөн
8	Тайлан дүгнэлтийн бүрдэл	Бүрэн
9	Судалгаа явуулсан ААН байгууллага	Энх-Өрнөлт
10	Тайлан, дүгнэлт бичсэн инженер	Ё Ариунаа
Дүгнэлтийн товч утга		
1	Судалгааны ажлын нэр төрөл, тоо хэмжээний норм дүрмийн хангалт	1-10м гүн 36 цооног, 52 дээж
2	Инженер-геологийн нөхцөл	дунд
3	Хөрсний усны түвшин	илрээгүй
4	Цэвдэг илэрсэн эсэх /ОЖЦ/	үгүй
5	Улирлын хөлдөлтийн гүн	зөв
6	Газар хөдлөлийн балл	8 балл
7	Газар шорооны ажлын зэрэг	зөв
8	Хөрсний овойлт	зөв
9	Хөрсний цахилгаан эсэргүүцэл	өгсөн
10	Ул хөрсний механик шинж чанарын норматив болон тооцооны үзүүлэлтүүд	өгсөн
Инженер-геологийн шийдэл нь дагаж мөрдөж буй норм, дүрэм, стандартын дагуу зохиогдсон эсэх		Хангасан
Дүгнэлт бичсэн: Эксперт № 11-9 Эксперт № 11-9 Г.Тунгалаг		
		2022 оны 06 сарын 02 өдөр



**Монгол Улс
Барилгын инженер-хайгуулын
“Энх-Өрнөлт” ХХК.**

**Ховд аймаг. Дарви сум. Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай
замтай Хөшөөтийн уурхайг холбох авто замын зураг
төсөлд зориулсан инженер-геологийн
судалгааны тайлан**

**Улаанбаатар хот.
2022 он**

Монгол Улс
Барилгын инженер-хайгуулын
“Энх-Өрнөлт” ХХК.



Архив № 22-035

ЗТН – 550/19



Ховд аймаг. Дарви сум. Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай
замтай Хөшөөтийн уурхайг холбох авто замын зураг
төсөлд зориулсан инженер-геологийн
судалгааны тайлан

/ Ажлын зургийн шатанд зориулав /

Батлав:



Захирал: /Б.Мөнхбадрах/

Хянасан: /Б.Саран/



Боловсруулсан: /Ё.Ариунаа/



Улаанбаатар хот.

2022 он

ГАРЧИГ

I. ОРШИЛ	3
1.1 Судалгаа хийсэн үндэслэл	3
1.2 Инженер-геологийн судалгааны ажлын хэмжээ, аргачлал	3
II. СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
2.1 Байршил	6
2.2 Маршрутын бичиглэл	6
2.2 Геоморфологийн хэв шинж, Физик-геологийн үзэгдэл үйл явц	10
2.3 Геологийн тогтоц	10
2.4 Гидрогеологийн нөхцөл	10
2.5 Цаг уур	10
III. СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ, УЛ ХӨРСНИЙ ФИЗИК-МЕХАНИК ШИНЖ ЧАНАР	14
3.1 Талбайн инженер-геологийн нөхцөл	14
3.2 Ул хөрсний физик-механик шинж чанар	14
IV. МАТЕРИАЛЫН ХАЙГУУЛ БА ТҮҮНИЙ ШИНЖ ЧАНАР	23
V. ТОВЧ ДҮГНЭЛТ	26
VI. ЦООНОГИЙН КАТОЛОГИ	29
VII. ЦООНОГИЙН БИЧИГЛЭЛ	30
Хавсралт материалууд	
1. Лабораторийн шинжилгээний үр дүнгийн хүснэгт	Хавсралт хүснэгт№1-6
2. Материалын шинжилгээ	Хавсралт хүснэгт№7-22
3. Малталтын байршлын зураг	Хавсралт зураг№1-19 Масштаб 1:14 000
4. Инженер-геологийн зүсэлт, таних тэмдэг	Хавсралт зураг№2-42 Масштаб Б 1:100 Х 1:5000

Ашигласан материал

1. Барилгын инженер-геологийн ажил БНбД 11-03-01
2. “Монгол орны нутаг дэвсгэрт шугаман байгууламжийн инженер-геологийн судалгаа хийх заавар БД 11-107-10
3. Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН-01-01-2004
4. Барилгад хэргэлэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНбД. 23-01-09.
5. Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрмийн тайлбар дүрэм БНбД 50-103-21
6. Инженер-геологийн судалгааны ажлын тайлан, дүгнэлт бичих дүрэм. БД-11-107-11. Улаанбаатар 2011 он.
7. Инструкция по применению электроразведочных методов в инженерных изысканиях для строительства
8. Газар хөдлөлийн бүс нутагт барилга байгууламж төлөвлөх БНбД 22-01-21 Улаанбаатар хот 2021 он.

I. ОРШИЛ

1.1 . Судалгаа хийсэн үндэслэл:

“Аварга зам” ХХК болон Барилгын инженер-геологийн “Энх-Өрнөлт” ХХК-ний хооронд байгуулсан инженер-геологийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээ, техникийн даалгаврын дагуу Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай замтай Хөшөөтийн уурхайг холбох авто замын зураг төсөлд зориулсан трассын дагуух инженер-геологийн судалгааг Барилгын инженер-геологийн “Энх-Өрнөлт” ХХК-аас 2022 оны 3-р сарын 28-ны өдрөөс 4-р сарын 25-ны өдөр хүртэл хээрийн судалгаа, лабораторийн шинжилгээ, суурин боловсруулалтын гэсэн 3 үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ.

1.2. Инженер-геологийн судалгааны ажлын хэмжээ, аргачлал:

- ❖ Судлагдсан авто замын трасс нь нийт 32,4 км урт үргэлжилнэ. Хээрийн судалгааны ажлыг явуулахдаа “Монгол орны нутаг дэвсгэрт шугаман байгууламжийн инженер-геологийн судалгаа хийх заавар БД 11-107-10, Барилгын инженер-геологийн судалгааны ажил гүйцэтгэх БНБД 11-03-01-ийн дагуу өрмийн УГБ-1ВС төхөөрөмжөөр, дээжлэлттэйгээр баганат өрөмдлөгийн аргаар өрөмдөв. Судалгааны явцад талбайн хөрсний тархалт, зүй тогтлыг тодорхойлох зорилгоор талбайн хэмжээнд 1.0-10,0 метрийн гүнтэй 36 цооногийг трассын дагууд 500-1000 метр орчмын зайтайгаар байрлуулж, нийт 148.9 тууш метр өрөмдөж хөрс чулуулгийн бичиглэлийг хийсэн ба замын трассын дагуух геоморфологийн тогтоц, физик-геологийн хүчин зүйлүүдэд ажиглалт судалгаа хийж фото зургаар баримтжуулан маршрутын бичиглэлд тусгав.
- ❖ Өрөмдсөн цооногуудаас хөрсний дээж авч лабораторийн туршилт шинжилгээ хийсэн бөгөөд шинжилгээний үр дүнг ашиглан хөрсний төрөл зүйлийг тогтоож нэгтгэн боловсруулав. Замын трассын дагуух материалын карьеруудыг тогтоож тус бүрд нь бүрэн дээжлэлттэйгээр өрөмдлөгийн ажил гүйцэтгэв.
- ❖ Хээрийн судалгаа, туршилтын ба лабораторийн шинжилгээний үр дүнг нэгтгэн боловсруулж энэхүү дүгнэлтийг бичсэн бөгөөд суурин боловсруулалтын ажилд захиалагчаас ирүүлсэн 1:4000 масштабтай байршлын зураг, Хэвтээ 1:5000, Босоо 1:100 масштабтай дагуугийн зүсэлтийг ашиглан малталтуудыг байрлуулж амсрын өндөржилтийг тогтоож өгөв.
- ❖ Судалгааны талбайд өрөмдсөн цооногуудын координатуудыг тогтоосон.
- ❖ Суурин боловсруулалтын ажлыг тухайн районд өмнө нь хийж байсан геологийн болон инженер-геологийн судалгааны материалуудыг судлаж, талбайн хэмжээнд хийсэн инженер-геологийн судалгааны материалуудыг эмхэтгэн тайланг 2 үе шаттайгаар боловсруулав. Үүнд:

Судалгааны бүх үе шатны ажлыг БНБД.11-03-01-ын 2-р бүлгийн үндсэн шаардлагын хүрээнд хийж гүйцэтгэж байгаа бөгөөд судалгааг дараах аргачлалаар явуулав. Үүнд:

1. Хээрийн судалгааны арга /Өрөмдлөгийн ажил болон ДСР-туршилт/
2. Лабораторийн шинжилгээний арга
3. Суурин боловсруулалтын аргаар хийж гүйцэтгэв.

1.1 Хээрийн судалгааны аргад өрөмдлөгийн ажил, ул хөрсний дээжлэлтийн ажлууд орно.

Өрөмдлөгийн ажил:

Инженер-геологийн хээрийн судалгааны өрөмдлөгийн ажлыг 2022-оны 3-дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн мэргэшсэн инженер Б.Мөнхбадрахын удирдлагаар өрмийн мастер Ү.Давгасүмбэрэл, өрмийн ажилчин Ө.Баярсайхан нарын бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн бөгөөд өрөмдлөг-малталтын ажлыг УГБ-1ВС, УГБ-50М маркийн өрмийн төхөөрөмжөөр баганат өрөмдлөгийн аргаар хийж гүйцэтгэв.



/Фото. Хээрийн ажлын өрөмдлөгийн явц/

Лабораторийн ажил:

Ул хөрсний физик-механик шинж чанарыг тодорхойлох зорилгоор 52 ш дээж авч лабораторийн шинжилгээг "Энх-Өрнөлт" ХХК-ний лабораторид тус лабораторийн хөрс судлаач Д.Тунгалаг хийв. Талбайд илэрсэн хөрсний физик-механик шинж чанарын үзүүлэлтүүдийг MNS 3263:2014-ээр ангилж, физик шинж чанарыг MNS 2143-2000-ын стандартуудын дагуу лабораторийн нөхцөлд хийж гүйцэтгэв.

Мөн материалын карьерт зориулж далангийн дүүргэлтэд 1, элсний 1, чулууны 1 дээж авч Зам тээврийн хөгжлийн төв зам барилгын эрдэм шинжилгээ, судалгааны итгэмжлэгдсэн төв лабораторид шинжилгээ хийлгэсэн. Дайрганы ширхэглэлийн бүрэлдэхүүнийг MNS AASHTO T27:2003 стандартын дагуу, элсний ширхэглэлийн бүрэлдэхүүнийг /MNS AASHTO T88:2004/, далан суурийн материалыг MNS ASTM D1883-2002 стандартуудын дагуу тодорхойлж тайланд хавсаргасан болно.


/Хавсралт хүснэгт үз/



/Лабораторийн нөхцөлд хувийн жинг тодорхойлж байгаа нь/



/Лабораторийн нөхцөлд уян налархайн туршилт хийж байгаа нь/



/Фото. Ширхэгийн бүрэлдэхүүн болон шаварлаг хэсгийн фракцын туршилт хэмжилт хийж байгаа нь/

Суурин боловсруулалтын ажил:

Суурин боловсруулалтын ажилд хээрийн тэмдэглэл болон лабораторийн шинжилгээний үр дүнг нэгтгэн боловсруулсаны үндсэн дээрээс дэвсгэр зурагт цооногуудыг байрлуулан тэдгээрийн зүсэлтийг зохиолоо.

Хээрийн өрөмдлөг судалгааны материал, лабораторийн шинжилгээний үр дүн, өмнөх судалгааны материал зэргийг харьцуулан боловсруулалт хийж судалгааны дүгнэлтийг мэргэшсэн инженер Ё.Ариунаа бичив.

II. СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Байршил:

Төлөвлөж байгаа авто замын трасс нь Ховд аймгийн Дарви сумын нутаг дэвсгэрт хамаарах ба Хөшөөтийн уурхайг холбосон нийт 32,4 км урт үргэлжилнэ. /Байршлын ерөнхий схем үз/



/Зураг-1. Судалгааны трассын ерөнхий чиглэл/

2.2. Маршрутын бичиглэл:


Трассын эхлэл Говь-Алтай-Ховдыг холбосон хатуу хучилттай авто замаас эхэлнэ. Цооног-1-ээс хөндийн хэв шинж давамгайлах ба уулс хоорондын хөндий трассын хэсэгт 10-15 км үргэлжилнэ. Хөндийн урдуур Баатар хайрханы нуруу Сутай уул, Дарвийн нуруу хойд талаар Чандманий нуруу, Мэргэн уул, Зэргийн гол оршино.




/Фото: Трассын эхлэл/

Цооног-21-ээс Ц-20 хооронд хуурай сайр-гүүрэн хоолой өндөр далангаар үргэлжилнэ. Хуурай сайрууд руу уулнаас хур бороо, шар ус цугларан даланг идэж,


нураасан байдалтай байгаа тул гадаргын уснаас хамгаалах, ус зайлуулах хоолой нэмэх шаардлагатай.



/Фото: Цооног -21-Ц-22 хооронд үүссэн жалга/



/Фото: Цооног -24-өөс трассын ерөнхий чиглэл/



/Фото: Цооног -26-гаас урагш 140 метр орчимд байх уруйн усны үйл ажиллагаагаар эвдэрсэн гүүр хоолой/



Уулын бэлээр өндөрлөг хэсгүүдийг ухмал болгож зассан сайжруулсан шороон замаар үргэлжилнэ. Цагаан хөтөл 46,872492N 93,23734E хүртэл бул чулуутай элс, элсэнцэр ул хөрс тархсан.

Цагаан хөтлөөс хойш тэгш бэлээр хаг шавранцар, элсэнцэр ул хөрс, элсэнцэр чигжээстэй хайрган ул хөрсүүд зонхилон тархана.



/Фото: Цооног -27 – уулнаас бууж ирэх шар усны идэгдлээс үүссэн жалга, том чулуутай гадарга/



/Фото: Цооног -28 - орчим гадаргын илэрцтэй хэсэг/

Цооног-1-ээс урагш кемп байгуулахаар чулуугаар гортиг татсаны гадна талд буюу цооногоос урагш 40 орчим метрт ухмалын зураг авав. 40 см өнгөн хөрсний дороос улаавтар хүрэн өнгийн боржингийн өгөршил илэрч тогтсон байна. Ан цаваар нилээд хэрчигдсэн.



/Фото: Цооног -29 - орчим ухмал болон гадаргын илэрцтэй хэсэг/

Цооног-29-цооног -30 хооронд сайрын урд тал буюу сайрны дэнжийн өндөр 18 м, хойд талын сайрын дэнжийн өндөр 10 м байлаа. Сайрын өргөн 40-50м, сайр дотор элсэн чулуу,

улаан хүрэн өнгийн боржин, конгломератын хэмхдэсүүд үерийн усаар зөөгдсөн нь ажиглагдана. Конгломератын гарш хойд дэнжийн хананд ажиглагдана.



/Фото: Цооног -29 -Цооног-30 хоорондох өргөн сайр/

Цооног-32-оос Цооног-34 хоорондох жалга нь 50-60 метрийн өргөнтэй, үерийн усаар зөөгдсөн том хэмхдэст чулуулгууд гадаргууд тархсан байна. Цооног-34 -ийн хойд талд 20 орчим метр зайд үндсэн чулуулгийн гарш илэрсэн. Трассын 25 дах км-ээс эхлэн үндсэн чулууны өгөршлийн бүс илэрнэ. Зарим хэсэгтээ гадаргууд гарш хэлбэрээр тархсан байна.



/Цооног-34-ийн хойд талд гадаргуудаа илэрцтэй хэсэг/

Цооног-36 буюу нүүрс зөөврийн засмал замын баруун ёроолд, Шунхлай ШТС-ын баруун урагш 500м орчимд уулын бэл хормойд хүрэн трасс төгсөнө.

Уурхайн удирдлагуудтай уулзаж ярилцахад хэрэгсүүр байгааг анхааруулсан бөгөөд газар дээр нь очиход хэрэгсүүрүүд нь чулуу овоолсон мэдэгдэхгүй байсан учир сүүлийн 7 цооногийн хоорондын зайг хол байршуулан өрөмдөв.



/Цооног-36. Трассын төгсгөл/

2.3. Геоморфологийн хэв шинж, физик-геологийн үзэгдэл үйл явц:

Судлагдсан талбай нь физик газарзүйн мужлалын хувьд Монгол Алтайн уулархаг их мужийн Алтайн мужид хамаарна. Баруун болон урд хэсгээрээ Цаст Богд, Гоотын нуруу, хойд талаараа Зэрэг, Дарвийн хоолойгоор, урд хэсгээрээ Салхит уул, Уушгийн хоолойгоор хүрээлэгддэг. Геоморфологийн ерөнхий тогтоцоороо зөөгдөл хуримтлалын рельеф болон өндөрлөг уулсын бэл хормойн хэсгээр үргэлжлэх бөгөөд трассын эхлэл хэсэгт гадаргын өндөржилт 1345,80 метр, дунд хэсэгт 1760,53 метр, трассын төгсгөлд 1953,87 метр байна. Трассын талбайд налуу хажууг дагасан уулын өвөр бэлээр хаврын шар усны үерийн болон намрын хур борооны улиралд гадаргын түр зуурын урсац үүсдэг бөгөөд энэ нь өвлийн улиралд орчиндоо халиа тошин үүсгэх нөхцөлтэй. Түр зуурын хүчтэй урсацууд орж олон тооны эрэг ганга, жалга судгуудыг үүсгэсэн нь сархиаг хэсэгт ажиглагдана. /Маршрутын бичиглэлээс фото зураг үз/

2.4 Геологийн тогтоц:

Судлагдсан талбайн хэмжээнд том хэмхдэс хурдас элбэг тархсан байх бөгөөд элсээр чигжигдсэн хайрга, хайргархаг элсэн ул хөрс өргөн тохиолддог. Энэ хөрс нь дунд дөрөвдөгчийн настай делюви-пролювийн /dpQ₂/ болон зарим хэсэг газартаа элсэнцэр болон хайрга агуулсан шавранцар хөрсүүд бага зузаантай илэрч тархсан байна. Трассын төгсгөл хэсэгт үндсэн чулууны гарштай, өгөршлийн үр дүнд үүссэн том хэмхдэст ул хөрсүүд тархана. /Инженер-геологийн зүсэлт үз/

2.5 Гидрогеологийн нөхцөл:


Талбайд өрөмдсөн 1,0-10,0 метрийн гүнтэй 36 цооногт хөрсний ус болон ОЖЦ хөрс илрээгүй. /2022 оны 3-р сарын байдлаар/.

2.6 Цаг үүр

Төлөвлөж байгаа авто замын зурвас талбайн цаг уурын үзүүлэлтүүдийг <<Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл>> АЗУАГН 2.01.01-2004 нормын үзүүлэлтүүдээр өглөө. Төлөвлөж байгаа авто замын зурвас талбай авто замын уур амьсгалын хээрийн бүс (II)-ийн уулсын завсар хоорондын дэд бүс (IIВ) –д хамаарна. Уур амьсгалын бүсийн тодорхойлолтыг 1-дүгээр хүснэгтэнд, бусад үзүүлэлтүүдийг II-1-15-дугаар хүснэгтүүдэд үзүүлэв.

Зураг №2

Монгол орны авто замын уур амьсгалын бүсчлэл



Монгол орны Авто замын уур амьсгалын бүсүүдийн инженер-геологийн нөхцөлийн тодорхойлолт

Хүснэгт II-1

Бүсийн дугаар, нэр	Дэд бүсийн индекс	Бүсийн товч тодорхойлолт	Цаг уурын болон инженер-геологийн зонхилох нөхцөл
1	2	3	4
II Авто замын уур амьсгалын хээрийн бүс	IIВ. Уулын завсар хоорондын дэд бүс	Авто замын уур амьсгалын хуурай хүйтэй, сэрүүвтэр хахир, хуурайдуу сэрүүвтэр бэсрэг уулт хээр	Эргэн тойрны говь цөлөрхөг бүсийг бодвол харьцангуй цасархаг, бороорхог аянгалаг, салхитай хахир хүйтэн. Зөөгдөлийн шаварлаг үелэл ихтэй элсэрхэг шаварлаг хурдас тархан.

Авто замын уур амьсгалын бүсүүдийн улирлын үргэлжлэх хугацаа*

Хүснэгт II- 2

Бүс	Дэд бүс	Өвөл			хавар		зун		намар
		эхлэл	дуусах	үргэлжлэх хоног	дуусах	үргэлжлэх хоног	дуусах	үргэлжлэх хоног	үргэлжлэх хоног
II	IIВ	1-9.XI 5..XI	15- 24.III 19.III	126-143 134	6-12.V 9.V	45-52 48	8- 19.IX 13.IX	112-156 129	44-54 49

Тайлбар : * Өвлийн дуусах хугацаа хаврын эхлэл, хаврынх зуны эхлэл, зуных намрын эхлэл, өвлийн эхлэл намрын дуусах хугацаа болно.

Хөрс, агаарын температур (°C) үзүүлэлт

Хүснэгт II-3

Бүс	Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °C				Агаар орчны дундаж температур, °C		
		Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0°нэвчих гүн, см*	Олон жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
1	2	3	4	5	6	7	8	9
II	IIВ	-0...+3	60-65	-41...-45	250-350	-2...+2	-20...-25	15...20

Тайлбар: * -0°C нэвчих гүн ул хөрсний төрлөөс хамаарах тул дээд доод хязгаарыг авав.

Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Хүснэгт II- 4

Бүс	Дэд бүс	Хөлдөлт			Гэсэлт		
		эхлэх	дуусах	хоног	эхлэх	дуусах	хоног
1	2	3	4	5	6	7	8
II	IIВ	20-30.X 25.X	15.III-30.IV 5.IV	120-195 160	15.III-10.IV 25.III	15.IV-31.V 23.IV	20-50 35

Авто замын барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой болон тохиромжгүй улирлын үеүд

Хүснэгт II- 5

Бүс	Дэд бүс	Дулааны улирал*			Хүйтний улирал
		эхлэх	дуусах	хоног	хоног
1	2	3	4	5	6
II	IIВ	10.IV	19.X	192	173

Тайлбар: * -Авто замын үйлдвэрлэлийн хүйтэн улирлын эх нь дулаан улирлын төгсгөл, хүйтэн улирлын төгсгөл нь дулаан улирлын эх болдог.

Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд, агаарын даралт, харьцангуй чийгшил

Хүснэгт II- 6

Бүс	Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм Нд баганын өндрөөр	Харьцангуй чийгшил, %
		өвөл	Хавар	зун	Намар		
1	2	3	4	5	6	7	8
II	IIВ	1.6-4	3-7	2-4	2.5-5.5	600-650	50-60

Авто замын уур амьсгалын бүсүүд дахь хур тундасны хэмжээ, мм

Хүснэгт II-7

Бүс	Дэд бүс	өвөл	Хавар	зун	намар	Жил	1 хоногт орох борооны хангамж, мм		Борооны хамгийн их орох эрчим мм/мин
							2%	1%	
1	2	3	4	5	6	7	8	9	10
II	IIВ	3-10	15-30	150-200	20-35	220-250	80	104	1-1.50

Авто замын уур амьсгалын бүсийн нарны цацраг, нарны гийгүүллийн хэмжээ

Хүснэгт II-8

Бүс	Дэд бүс	Нарын цацраг, Мд/м ²			Нарны гийгүүлэл, цаг				
		нийлбэр	шууд	шингэсэн	Жил	XII	VI	XII сарын I өдөрт	VI сарын I өдөрт
1	2	3	4	5	6	7	8	9	10
II	IIВ	4500-5300	2700-3200	3500-3700	2700-3300	150-200	270-300	6-7	9-10

Авто замын техник ашиглалтын түвшинд сөргөөр нөлөөлж болох уур амьсгалын үзэгдлүүд, тэдгээрийн үйлчлэл, мөчлөгийн хэмжээ

Хүснэгт II-9

Бүс	Дэд бүс	Техникийн уур амьсгалын хахир хатуу, балл		Уур амьсгалын хахиршил, балл	Нийт аянгийн үйлчлэл		1 аянгийн	
		Хүйтний	Дулааны		Өдрийн тоо	Үргэлжлэл, цаг	Үргэлжлэл минут	1 км ² талбайн ниргэлтийн тоо
1	2	3	4	5	6	7	8	9
II	IIВ	50-60	20-25	3-3,5	25-35	40-45	80-110	5-6

Хүснэгт II-9-ийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Нойтон цастай		Хялмаатай		Мөстлөгтэй		
		Өдрийн тоо	Үргэлжлэх цаг	Өдрийн тоо	Үргэлжлэх цаг	Өдрийн тоо	Зузаан, мм 10 жилд	Зузаан, мм 5 жилд
1	2	10	11	12	13	14	15	16
II	IIВ	3-5	3-4	3-5	10-13	1-2	10	5

Хүснэгт II-9-ийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Ачаалал, кг/м ²		Металлын зэврэлт болох хугацаа, цаг	Тохиромжгүй өдрийн тоо					
		Салхины	Цасны		Халуун	Цасан шуурга-тай	Шороон шуурга-тай	Хүчтэй саохитай	Бороотой	Цастай
1	2	17	18	19	20	21	22	23	24	25
II	IIВ	40-55	40-60	1500-2000	25-40	3-4	10-30	8-15	40-60	20-35

Хүснэгт II-9-ийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Халууны нөөц, нийлбэр °C		Хүйтний нөөц, нийлбэр °C			Хүйтний үргэлжлэх хугацаа, цаг		
		+20	+25	-20	-25	-30	-20°C	-30°C	-40°C
1	2	26	27	28	29	30	31	32	33
II	IIВ	800-2000	1000-1300	-300-2000	-900-1000	-1000-1500	1300-1600	200-400	200-400

Хүснэгт II-9-ийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Тогтвортой цасан бүрхүүл					
		Тогтох	Ханзрах	Хоног	Хамгийн зузааны дундаж, см	Нягт г/см ³	Нөөц ус, мм
1	2	34	35	36	37	38	39

II	IIВ	20.XI-1.XII	10-20.III	60-120	10-15	0.20-0.25	10-20
----	-----	-------------	-----------	--------	-------	-----------	-------

Хүснэгт II- 9-ийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Тогтвортой хүйтэн үед цочир дулааралттай, замд хальтиргаа гулгаатай байх хугацаа		Хүйтэн улирлын жавар хавсрагатай (>8м/с), хахир үе		Хөрсний 0-50 см гүний чийгшлийн нөөц, мм	
		Эхлэх	Дуусах	Өдрийн тоо	Цаг	Хавар	Намар
1	2	40	41	42	43	44	45
II	IIВ	1.XII	15.III	100-125	500-650	10-30	30-50

Гол мөрний гадаргын усны горимын зарим үзүүлэлт

Хүснэгт II-10

Бүс	Дэд бүс	Гол мөрний гадаргын усны							
		Нягтшил	Жилийн дундаж урсац, л/сек	Дундаж урсацын давхраа, мм	Хаврын шар усны үерийн хамгийн их урсац, мм	Хамгийн их урсацын модуль, л/сек. ам.км	Мөсний хамгийн их зузааны дундаж, см	Мөс хадаалах хугацаа	Мөс задрах хугацаа
1	2	3	4	5	6	7	8	9	10
II	IIВ	0,04-0,2	1-2	25-100	10-100	0,4-0,8	100-125	10-20.XI	21.V-с эрт

Хээр гадаа ажиллах авто замын ажилчдын хөдөлмөрийн био уур амьсгалын нөхцөл

Хүснэгт II-11

Бүс	Дэд бүс	Хүчил төрөгчийн нягт, г/см ³	Хувцас хунарын дулаан чанар, КЛО (хүндэвтэр ажлын нөхцөлөөр тооцов)			Уур амьсгал хүний биед, хоног		
			Өвлийн	Хавар, намрийн	Зуны	Таатай	Цочроох	Хурц
1	2	3	4	5	6	7	8	9
II	IIВ	250-260	4,6-5,5	2,8-3,0	1,5-1,7	175-190	110-120	80-90

Авто замын үйлдвэрлэл, замчдын хөдөлмөрт уур амьсгалын нөлөөллийг үнэлэх итгэлцүүрүүд

Хүснэгт II-12

Бүс	Дэд бүс	Асфальто болон замын хучилт				
		Хүйтний	Хахирын	Халууны	Хур тунадасны	чийгшлийн
1	2	3	4	5	6	7
II	IIВ	1,00	1,00	1,00	1,00	1,00

Хүснэгт II-12-ын үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр			
		Хүчтэй салхи шуурганы	Аянга цахилгааны	1 удаагийн их борооны	Цасны
1	2	3	4	5	6
II	IIВ	1,00	1,00	1,00	1,00

Хүснэгт II-12-ын үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр					Уур амьсгалын үндсэн итгэлцүүр
		Хөдөлмөр хамгааллын хувцасны нөлөөлөл			Хүний биед уур амьсгалын нөлөөлөл		
		Өвөл	Хавар, намар	Зун	Таатай	Цочроох	

1	2	7	8	9	10	11	12	13
II	IIВ	1,00	1,00	1,00	1,00	1,00	1,00	1,00

Авто замын уур амьсгалын бүсүүдэд халуун асфальт бетон хольц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа

Хүснэгт II-13

Бүс	Дэд бүс	Асфальто болон замын хучилт		
		Эхлэх	Дуусах	Хоног
1	2	3	4	5
II	IIВ	18.IV-16.V (2.V)	15.III-19.IX (1.IX)	91-154 (122)

Авто замын уур амьсгалын бүсүүдэд хүйтэн, бүлээн асфальт бетон хучилт хийхэд тохиромжтой хугацаа

Хүснэгт II-14

Бүс	Дэд бүс	Асфальто болон замын хучилт		
		Эхлэл	Дуусах	Хоног
1	2	3	4	5
II	IIВ	3-30.III (16.III)	30.X-4.XII (15.XI)	220-278 (250)

Авто замын шороон далангийн чийг-дулааны горимын мөчлөгүүд

Хүснэгт II-15

Бүс	Дэд бүс	Замын даланд намар чийг хуримтлагдах			Даланд өвлийн чийг хуримтлагдах		Замын хөрс гэсэж чийг нэмэгдэх		Замын далан хуурайших
		Эхлэх	Дуусах	хоног	Дуусах	хоног	Дуусах	Хоног	Хоног
1	2	3	4	5	6	7	8	9	10
II	IIВ	10.X	15. XI	36	1.IV	137	20.V	49	143

III. СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ, УЛ ХӨРСНИЙ ФИЗИК-МЕХАНИК ШИНЖ ЧАНАР

III.1 Талбайн инженер-геологийн нөхцөл

Төлөвлөж буй трассын талбай нь инженер-геологийн төвөгшлийн ангиллаар дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй.

III.2 Ул хөрсний физик-механик шинж чанар

Төлөвлөж байгаа трассын дагуух талбайн өнгөн хөрс болон замын далангийн хучаас болох хайрганы дороос тархсан ул хөрсүүдийг инженер-геологийн 8 элемент (ИГЭ)-д ангилан тус бүрийн физик-механик шинж чанарын үзүүлэлтүүдийг өглөө.

Ул хөрсний тархалт, зузаалгийг инженер-геологийн зүсэлт зургаар үзүүлэв.
/Хавсралт зураг №18-38/

Өнгөн хөрс. Ургамлын үндэс бүхий өнгөн хөрс нь судлагдсан трассын дагууд 0,2 метрийн зузаантайгаар жигд тархсан байна.

ИГЭ-1. Хайргархаг элсэн ул хөрс.

Голоцены настай орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, цайвар шаргал өнгийн бага чийгтэй, хайргархаг элсэн ул хөрс. /Инженер-геологийн зүсэлт үз/.

Хайргархаг элсэн ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 36,3
- янз бүрийн ширхэгтэй элс 57,0
- тоос 4,7
- шаварлаг хэсэг 2,0 тус тус агуулагдана.

Хайргархаг элсэн ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-1-д нэгтгэн үзүүлбэл:
Хүснэгт III-1

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	нэгжийн хувь	0.037
2	Хатуу хэсгийн нягт	г/см ³	2.66
3	Хөрсний нягт	г/см ³	2,13
4	Эрдэслэг хэсгийн нягт	г/см ³	2,05
5	Сүвшил	хувь	22,65
6	Сүвшлийн коэффициент	нэгжийн хувь	0.293
7	Чийглэгийн зэрэг	нэгжийн хувь	0.33

Хайргархаг элсэн ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНбД50-103-21 нормын 4,1-р хүснэгтээр тооцож хүснэгт III-2-д нэгтгэн үзүүлбэл:
Хүснэгт III-2

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C ^н	C ^I	C ^{II}	φ ^н	φ ^I	φ ^{II}	E ^н
2	1,3	2	43	38,7	43	50

Хайргархаг элсэн ул хөрс нь улирлын хөлдөлтийн бүсэд овойлт үүсгэхгүй хөрсөнд нормчлогдоно. Хайргархаг элсэн ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – III.

ИГЭ-2. Элсээр чигжигдсэн хайрган ул хөрс.

Голоцены настай орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, цайвар шаргал өнгийн бага чийгтэй, элсээр чигжигдсэн хайрган ул хөрс.
/Инженер-геологийн зүсэлт үз/.

Элсээр чигжигдсэн хайрган ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 54.2
- янз бүрийн ширхэгтэй элс 39,0
- тоос 4.9
- шаварлаг хэсэг 1.9 тус тус агуулагдана.

Элсээр чигжигдсэн хайрган ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-3-д нэгтгэн үзүүлбэл:
Хүснэгт III-3

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	нэгжийн хувь	0.033
2	Хатуу хэсгийн нягт	г/см ³	2.65
3	Хөрсний нягт	г/см ³	2,19
4	Эрдэслэг хэсгийн нягт	г/см ³	2,12

5	Сүвшил	хувь	19,98
6	Сүвшлийн коэффициент	нэгжийн хувь	0.250
7	Чийглэгийн зэрэг	нэгжийн хувь	0.35

Элсээр чигжигдсэн хайрган ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНбД50-103-21 нормын 4,1-р хүснэгтээр тооцож хүснэгт III-4-д нэгтгэн үзүүлбэл:

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C ^н	C ^I	C ^{II}	φ ^н	φ ^I	φ ^{II}	E ^н
2	1,3	2	43	38,7	43	50

Элсээр чигжигдсэн хайрган ул хөрс нь улирлын хөлдөлтийн бүсэд овойлт үүсгэхгүй хөрсөнд нормчлогдоно. Элсээр чигжигдсэн хайрган ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – IV.

ИГЭ-3. Хайргархаг элсэнцэр үл хөрс.

Голоцены настай орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, цайвар шаргал өнгийн хатуу урсамтгайн үзүүлэлттэй, хайргархаг элсэнцэр үл хөрс. /Инженер-геологийн зүсэлт үз/.

Хайргархаг элсэнцэр үл хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 35,7
- янз бүрийн ширхэгтэй элс 42,8
- тоос 14,1
- шаварлаг хэсэг 7,4 тус тус агуулагдана.

Хайргархаг элсэнцэр үл хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-5-д нэгтгэн үзүүлбэл:

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	нэгжийн хувь	0.059
2	Урсалтын хязгаар дахь чийг	нэгжийн хувь	0.182
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг	нэгжийн хувь	0.136
4	Уян налархайн тоо	нэгжийн хувь	0.047
5	Хатуу хэсгийн нягт	г/см ³	2.68
6	Хөрсний нягт	г/см ³	2,14
7	Эрдэслэг хэсгийн нягт	г/см ³	2,02
8	Сүвшил	хувь	24,66
9	Сүвшлийн коэффициент	нэгжийн хувь	0.329
10	Чийглэгийн зэрэг	нэгжийн хувь	0.48
11	Урсамтгайн үзүүлэлт		<0

Хайргархаг элсэнцэр үл хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНбД50-103-21 нормын 4,4-р хүснэгт болон 4,5-р хүснэгтээр тооцож хүснэгт III-6-д нэгтгэн үзүүлбэл:

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C ^н	C ^I	C ^{II}	φ ^н	φ ^I	φ ^{II}	E ^н

21	14	21	30	26	30	32
----	----	----	----	----	----	----

Хайргархаг элсэнцэр ул хөрсний овойлт $R_f=0,009$ байгаа нь овойлт үүсгэхгүй. Хайргархаг элсэнцэр ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – III.

ИГЭ-4. Элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрс.

Голоцены настай орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, цайвар шаргал өнгийн хатуу урсамтгайн үзүүлэлттэй, элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрс. /Инженер-геологийн зүсэлт үз/.

Элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 55,2
- янз бүрийн ширхэгтэй элс 27,0
- тоос 10,4
- шаварлаг хэсэг 7,4 тус тус агуулагдана.

Элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-7-д нэгтгэн үзүүлбэл: Хүснэгт III-7

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	нэгжийн хувь	0.060
2	Урсалтын хязгаар дахь чийг	нэгжийн хувь	0.186
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг	нэгжийн хувь	0.130
4	Уян налархайн тоо	нэгжийн хувь	0.056
5	Хатуу хэсгийн нягт	г/см ³	2.69
6	Хөрсний нягт	г/см ³	2,21
7	Эрдэслэг хэсгийн нягт	г/см ³	2,09
8	Сүвшил	хувь	22,36
9	Сүвшлийн коэффициент	нэгжийн хувь	0.289
10	Чийглэгийн зэрэг	нэгжийн хувь	0.55
11	Урсамтгайн үзүүлэлт		<0

Элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНБД50-103-21 нормын 4,6 болон 4,8-р хүснэгтээр тооцож хүснэгт III -8-д нэгтгэн үзүүлбэл: Хүснэгт III-8

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C^H	C^I	C^{II}	φ^H	φ^I	φ^{II}	E^H
17	11,3	17	44	38	44	42,5

Элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрсний ширхэглэлийн нунтаглалын үзүүлэлт $D=0,51$ чийглэгийн зэрэг $S_r=0,55$ байгаа нь овойлт үүсгэхгүй. Элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – IV.

ИГЭ-5. Хайрга агуулсан шавранцар ул хөрс.

Голоцены настай орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, бор хүрэн өнгийн хатуу урсамтгайн үзүүлэлттэй, хайрга агуулсан шавранцар ул хөрс. /Инженер-геологийн зүсэлт үз/.

Хайрга агуулсан шавранцар ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 11,9
- янз бүрийн ширхэгтэй элс 45,6
- тоос 26,3
- шаварлаг хэсэг 16,2 тус тус агуулагдана.

Хайрга агуулсан шавранцар ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-9-д нэгтгэн үзүүлбэл: Хүснэгт III-9

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	нэгжийн хувь	0.119
2	Урсалтын хязгаар дахь чийг	нэгжийн хувь	0.245
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг	нэгжийн хувь	0.158
4	Уян налархайн тоо	нэгжийн хувь	0.087
5	Хатуу хэсгийн нягт	г/см ³	2.71
6	Хөрсний нягт	г/см ³	1,97
7	Эрдэслэг хэсгийн нягт	г/см ³	1,76
8	Сүвшил	хувь	34,99
9	Сүвшлийн коэффициент	нэгжийн хувь	0.544
10	Чийглэгийн зэрэг	нэгжийн хувь	0.59
11	Урсамтгайн үзүүлэлт		<0

Хайрга агуулсан шавранцар ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНБД50-103-21 нормын 4,4-р хүснэгт болон 4,5-р хүснэгтээр тооцож хүснэгт III-10-д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-10

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C ^н	C ^I	C ^{II}	φ ^н	φ ^I	φ ^{II}	E ^н
37	24,6	37	25	21,7	25	27

Хайрга агуулсан шавранцар ул хөрсний овойлт Rf=0,030 байгаа нь дунд зэргийн овойлт үүсгэнэ. Хайрга агуулсан шавранцар ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – II.

ИГЭ-6. Хайргархаг шавранцар ул хөрс.

Голоцены настай орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, бор хүрэн өнгийн хатуу урсамтгайн үзүүлэлттэй, хайргархаг шавранцар ул хөрс. /Инженер-геологийн зүсэлт үз/.

Хайргархаг шавранцар ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 34,2
- янз бүрийн ширхэгтэй элс 34,0
- тоос 16,7
- шаварлаг хэсэг 15,1 тус тус агуулагдана.

Хайргархаг шавранцар ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-11-д нэгтгэн үзүүлбэл: Хүснэгт III-11

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
-----	--------------------------------	--------------	-------------

1	Байгалийн чийг	нэгжийн хувь	0.115
2	Урсалтын хязгаар дахь чийг	нэгжийн хувь	0.239
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг	нэгжийн хувь	0.155
4	Уян налархайн тоо	нэгжийн хувь	0.084
5	Хатуу хэсгийн нягт	г/см ³	2.71
6	Хөрсний нягт	г/см ³	2,12
7	Эрдэслэг хэсгийн нягт	г/см ³	1,90
8	Сүвшил	хувь	29,98
9	Сүвшлийн коэффициент	нэгжийн хувь	0.428
10	Чийглэгийн зэрэг	нэгжийн хувь	0.72
11	Урсамтгайн үзүүлэлт		<0

Хайргархаг шавранцар ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНбД50-103-21 нормын 4,4-р хүснэгт болон 4,5-р хүснэгтээр тооцож хүснэгт III-12-д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-12

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C ^H	C ^I	C ^{II}	φ ^H	φ ^I	φ ^{II}	E ^H
47	31,3	47	26	22,6	26	34

Хайргархаг шавранцар ул хөрсний овойлт $R_f=0,028$ байгаа нь дунд зэргийн овойлт үүсгэнэ. Хайргархаг шавранцар ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – III.

ИГЭ-7. Жижиг ширхэгтэй элсэн ул хөрс.

Голоцены настай орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, цайвар шаргал өнгийн бага чийгтэй, жижиг ширхэгтэй элсэн ул хөрс. /Инженер-геологийн зүсэлт үз/.

Жижиг ширхэгтэй элсэн ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 0,0
- янз бүрийн ширхэгтэй элс 89,6
- тоос 8,1
- шаварлаг хэсэг 2,3 тус тус агуулагдана.

Жижиг ширхэгтэй элсэн ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-13-д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-13

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	нэгжийн хувь	0.056
2	Хатуу хэсгийн нягт	г/см ³	2.66
3	Хөрсний нягт	г/см ³	2,01
4	Эрдэслэг хэсгийн нягт	г/см ³	1,90
5	Сүвшил	хувь	28,44
6	Сүвшлийн коэффициент	нэгжийн хувь	0.397
7	Чийглэгийн зэрэг	нэгжийн хувь	0.37

Жижиг ширхэгтэй элсэн ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНБД50-103-21 нормын 4,1 болон 4,2-р хүснэгтээр тооцож хүснэгт III-14–д нэгтгэн үзүүлбэл: Хүснэгт III-14

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C ^н	C ^I	C ^{II}	φ ^н	φ ^I	φ ^{II}	E ^н
6	4	6	38	34,2	38	48

Жижиг ширхэгтэй элсэн ул хөрс нь улирлын хөлдөлтийн бүсэд овойлт үүсгэхгүй хөрсөнд нормчлогдоно. Жижиг ширхэгтэй элсэн ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – I.

ИГЭ-8. Том ширхэгтэй элсэн ул хөрс.

Голоцены настай орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, цайвар шаргал өнгийн бага чийгтэй, том ширхэгтэй элсэн ул хөрс. /Инженер-геологийн зүсэлт үз/.

Том ширхэгтэй элсэн ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 0,0
- янз бүрийн ширхэгтэй элс 95,0
- тоос 3,0
- шаварлаг хэсэг 2,0 тус тус агуулагдана.

Том ширхэгтэй элсэн ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-15-д нэгтгэн үзүүлбэл: Хүснэгт III-15

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	нэгжийн хувь	0.053
2	Хатуу хэсгийн нягт	г/см ³	2.66
3	Хөрсний нягт	г/см ³	2,01
4	Эрдэслэг хэсгийн нягт	г/см ³	1,90
5	Сүвшил	хувь	28,42
6	Сүвшлийн коэффициент	нэгжийн хувь	0.397
7	Чийглэгийн зэрэг	нэгжийн хувь	0.36

Том ширхэгтэй элсэн ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНБД50-103-21 нормын 4,1 болон 4,2-р хүснэгтээр тооцож хүснэгт III-16–д нэгтгэн үзүүлбэл: Хүснэгт III-16

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C ^н	C ^I	C ^{II}	φ ^н	φ ^I	φ ^{II}	E ^н
2	1,3	2	43	38,7	43	50

Том ширхэгтэй элсэн ул хөрс нь улирлын хөлдөлтийн бүсэд овойлт үүсгэхгүй хөрсөнд нормчлогдоно. Том ширхэгтэй элсэн ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – I.

ИГЭ-9. Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрс.

Орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, бор хүрэн өнгийн хатуу урсамтгайн үзүүлэлттэй, шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрс. /Инженер-геологийн зүсэлт үз/.

Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга	58,1
- янз бүрийн ширхэгтэй элс	18,9
- тоос	7,7
- шаварлаг хэсэг	15,3 тус тус агуулагдана.

Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-17-д нэгтгэн үзүүлбэл: Хүснэгт III-17

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	нэгжийн хувь	0.070
2	Урсалтын хязгаар дахь чийг	нэгжийн хувь	0.253
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг	нэгжийн хувь	0.159
4	Уян налархайн тоо	нэгжийн хувь	0.094
5	Хатуу хэсгийн нягт	г/см ³	2.72
6	Хөрсний нягт	г/см ³	2,21
7	Эрдэслэг хэсгийн нягт	г/см ³	2,07
8	Сүвшил	хувь	24,07
9	Сүвшлийн коэффициент	нэгжийн хувь	0.317
10	Чийглэгийн зэрэг	нэгжийн хувь	0.60
11	Урсамтгайн үзүүлэлт		<0

Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНБД50-103-21 нормын 4,6 болон 4,8-р хүснэгтээр тооцож хүснэгт III -18-д нэгтгэн үзүүлбэл: Хүснэгт III-18

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C ^н	C ^I	C ^{II}	φ ^н	φ ^I	φ ^{II}	E ^н
25	16,6	25	41	35,6	41	40

Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний ширхэглэлийн нунтаглалын үзүүлэлт D=0,002 чийглэгийн зэрэг Sr=0,60 байгаа нь овойлт үүсгэхгүй. Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – IV.

ИГЭ-10. Үндсэн чулууны өгөршлийн бүс. Шавранцараар чигжигдсэн хайрга болтлоо өгөршсөн байна.

Орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, элювийн гаралтай, хатуу урсамтгайн үзүүлэлттэй, хөх саарлаас улаавтар хүрэн өнгийн үндсэн чулууны өгөршил бутарлын үр дүнд үүссэн шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрс. /Инженер-геологийн зүсэлт үз/.

Үндсэн чулууны өгөшрлийн ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга	65,0
- янз бүрийн ширхэгтэй элс	14,9
- тоос	10,6
- шаварлаг хэсэг	9,5 тус тус агуулагдана.

Үндсэн чулууны өгөшрлийн үр дүнд үүссэн шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-19-д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-19

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	нэгжийн хувь	0.044
2	Урсалтын хязгаар дахь чийг	нэгжийн хувь	0.270
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг	нэгжийн хувь	0.169
4	Уян налархайн тоо	нэгжийн хувь	0.101
5	Хатуу хэсгийн нягт	г/см ³	2.74
6	Хөрсний нягт	г/см ³	2,22
7	Эрдэслэг хэсгийн нягт	г/см ³	2,13
8	Сүвшил	хувь	22,25
9	Сүвшлийн коэффициент	нэгжийн хувь	0.286
10	Чийглэгийн зэрэг	нэгжийн хувь	0.42
11	Урсамтгайн үзүүлэлт		<0

Үндсэн чулууны өгөшрлийн үр дүнд үүссэн шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНБД50-103-21 нормын 4,7 болон 4,9-р хүснэгтээр тооцож хүснэгт III -20-д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-20

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C ^н	C ^I	C ^{II}	φ ^н	φ ^I	φ ^{II}	E ^н
14,5	9,6	14,5	32	27,8	32	37,5

Үндсэн чулууны өгөшрлийн дүнд үүссэн шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний ширхэглэлийн нунтаглалын үзүүлэлт D=0,048 чийглэгийн зэрэг Sr=0,42 байгаа нь овойлт үүсгэхгүй. Үндсэн чулууны өгөшрлийн үр дүнд үүссэн шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – V.

ИГЭ-10а. Үндсэн чулуу

Хөх саарал болон улаавтар хүрэн өнгөтэй, өгөршилд их орж ан цавшсан, доод палеозойн настай боржин. Өгөршлийн зэрэг K_{вс}=0,43 байгаа нь бага өгөршсөн хадан хөрсөнд норчлогдоно. Дээжүүдэд хийсэн судалгааны лабораторийн шинжилгээний үр дүнгээс үзвэл эзэлхүүн жин нь 2,58 гр/см³ байна. /Инженер-геологийн зүсэлт үз/. Газар шорооны ажлын зэрэг -VII

Боржин чулууны лабораторийн үзүүлэлтүүд

Хүснэгт III-21


№	Чулууны элэгдэх шинж чанар тодорхойлох туршилтын үр дүн		Чулууны физик үзүүлэлтүүд			Чулууны механик шинж чанарын үзүүлэлтүүд	
1	Туршилтын өмнөх дээжийн жин., гр	2800	Эзэлхүүн жин	2.58 гр/см ³		Хэв гажилтын модуль E.	152 МПа
2	Туршилт хийсний дараах дээжийн жин., гр	2460	Өгөршлийн зэрэг	K _{вг} =0.43		Барагцаалсан тооцооны эсэргүүцэл R _о	600 кПа/6.0 кг/см ³
3	Чулууны элэгдэлийн хэмжээ., гр	250	Нэг чиглэлийн шахагдалд үзүүлэх цаг зуурын эсэргүүцэл	Байгалийн чийгтэй үед	R _c =20-8 МПа		
4	Чулууны элэгдэлийн хувь %	10.0		Усаар ханасан үед	R _c =45-20МПа		
5	Чулууны нягт	2.74					

IV. Материалын хайгуул ба түүний шинж чанар.

4.1 CBR, Прокторын үр дүн:

Карьер № 1.

Далангийн карьер. Трассын 19+00 км-ээс зүүн тийш 315 орчим зайд хуучин ашиглаж байсан карьераас далангийн материалд зориулж 1ш дээж авсан болно. Карьерийн талбай хүрэлцээтэй нөөц ашиглах боломжтой. Карьерийн GPS-ийн солбилцол 517593 m E 5192127 m N



/Зураг. Google earth масштабгүй/



/Фото. Далангийн карьерийн байршил/

Материалын шинжилгээнд зориулж авсан дээжийн жин далан суурийн материалд 70 кг

Далангийн материалын карьер


Хүснэгт IV-1

№	Шинжилсэн үзүүлэлт <i>Test parameter</i>	Шинжилгээний аргын стандарт <i>Method of analysis</i>	Хэмжих нэгж <i>Unit</i>	Техникийн шаардлага <i>Test specification</i>	Үр дүн <i>Test results</i>
1	37.5мм	MNS ASTM D 2217:2002	%		100.00
2	25.0 мм	MNS ASTM D 2217:2002	%	80-100	96.63
3	19.0 мм	MNS ASTM D 2217:2002	%	60-90	94.14
4	9.5 мм	MNS ASTM D 2217:2002	%	30-65	85.25
5	4.75 мм	MNS ASTM D 2217:2002	%	25-55	69.44
6	2.36 мм	MNS ASTM D 2217:2002	%	15-40	54.17
7	0.425 мм	MNS ASTM D 2217:2002	%	8-20	28.91
8	0.075 мм	MNS ASTM D 2217:2002	%	5-10	14.11
9	Ачаа даацын харьцаа	MNS ASTM D 1883:2002	%	>30	19
10	Чийгийн тохиромжтой агуулалт	MNS ASTM D 1557:2002	%		6.97
11	Хуурай үеийн хамгийн их нягт	MNS ASTM D 1557:2002	г/см ³	>1.85	2.160
12	Уян налархайн индекс	MNS ASTM D 4318:2006	%	<6	2.02
13	Урсалтын хязгаар	MNS ASTM D 4318:2006	%	<25	20.16
14	Уян налархайн хязгаар	MNS ASTM D 4318:2006	%		18.14

Лабораторийн үр дүнгээс үзвэл ачаа даацын үзүүлэлтээрээ далангийн дүүргэлтэнд хэрэглэх материалын техникийн шаардлага хангахгүй байна. /Шинжилгээний үр дүнг тайланд хавсаргав/.

Карьер № 2.

Чулууны карьер. Трассын эхлэлээс зүүн хойш 2,8 км-т чулууны 1ш дээж авсан болно. Карьерийн талбай хүрэлцээтэй нөөц ашиглах боломжтой . Карьерийн GPS-ийн солбилцол 518261.00m E 5212669.00 m



/Зураг. Google earth масштабгүй, чулууны карьерийн байршил/

Материалын шинжилгээнд зориулж авсан дээжийн жин далан суурийн материалд 50 кг

Чулууны карьер: Шинжилгээний үр дүнг товч дурьдвал:

Чулуун материалын дээжийн шинжилгээний физик үзүүлэлтүүд:

Хүснэгт IV-2

№	Шинжилсэн үзүүлэлт <i>Test parameter</i>	Шинжилгээний аргын стандарт <i>Method of analysis</i>	Хэмжих нэгж <i>Unit</i>	Техникийн шаардлага <i>Test specification</i>	Үр дүн <i>Test results</i>
1	Ширхэгийн дундаж нягт	MNS 2998:2009	г/см ³	>2.4	2.710
2	Цохилттой бутрагдалт	MNS BS 812-112:2003	%	<25	14.09
3	Чулууны марк	MNS 2998:2009	-	600-1200	1000
4	Элэгдэх чанар	MNS ASTM C 535:2003	%	<25	17.36
5	Цилиндр бутрагдалт	MNS 2998:2009	%	<15	10.78
6	Хүйтэн тэсвэрлэлт	MNS ASTM C 88:2004	%	<12	11.2
7	Ус шингээлт	MNS 2998:2009	%	<2	1.353

• **Чулууны бутрагдалтын хэмжээ: /ЧБХ/**

Гэнэтийн цохиолт болон нөлөөлөлд үзүүлэх дүүргэгчийн эсэргүүцлийг харьцангуй утгыг ЧБХ тодорхойлдог. ЧБХ-г тодорхойлох зорилгоор шинжилсэн дээжийн ЧБХ нь 14,09 % байгаа нь техникийн шаардлагыг хангаж байна.

• **Чулууны элэгдлийг тодорхойлох: /ЧЭТ/**

ЧЭТ арга нь замд хэрэглэх чулуун дүүргэгч материалын хатуулгийг тогтооход түгээмэл хэрэглэгддэг арга юм. Шинжилсэн дээжийн элэгдлийн хэмжээ нь 17,36% байгаа нь эдгээр материалыг буталсан чулуун суурь болон асфальт бетон хучилтын үед ашиглах боломжтойг баталж байна.

• **Хувийн жин:**

Шинжилгээ хийсэн дээжийн хувийн жин 2,71 г/см³ байгаа нь хэвийн үзүүлэлт бөгөөд лабораторид шинжлүүлсэн чулуу нь 1000 маркийн чулуу байна. Тус чулуун цемент бетон болон асфальтобетонд ашиглахад тохиромжтой гэж үзэж байна. /Шинжилгээний үр дүнг тайланд хавсаргав/.

• **Ус шингээлт:**


Ус шингээлт нь 1,353 байгаа нь зөвшөөрөгдөх 2 %-иас бага байгаа нь чулуулгийг замын хучилт болон суурь үед ашиглахад тохиромжтой. /Шинжилгээний дэлгэрэнгүй үр дүнг тайланд хавсаргав/

Карьер № 3.

Элсний карьер.

Трассын эхлэлээс зүүн хойш 1,8 км-т элсний 1ш дээж авсан болно. Карьерийн талбай хүрэлцээтэй нөөц ашиглах боломжтой .

Карьерийн GPS-ийн солбилцол 518764.00 m E 5211134.00 m



/Зураг. Google earth масштабгүй, байгалийн элсний байршил/

Элсний карьераас авсан дээжинд ширхэглэлийн бүрэлдэхүүн болон жижиг ширхэглэлтэй модуль тодорхойлох шинжилгээнүүдийг хийсэн.

Шинжилгээний үр дүнг товч дурьдвал:

Хүснэгт IV-3

№	Шинжилсэн үзүүлэлт <i>Test parameter</i>	Шинжилгээний аргын стандарт <i>Method of analysis</i>	Хэмжих нэгж <i>Unit</i>	Техникийн шаардлага <i>Test specification</i>	Үр дүн <i>Test results</i>
1	0.075-р өнгөрсөн	MNS 2916:2014	%		5.45
2	19.0 мм	MNS AASHTO T88 : 2014	%	100	100.00
3	12.5 мм	MNS AASHTO T88 : 2014	%	100	100.00
4	9.5 мм	MNS AASHTO T88 : 2014	%	100	93.2
5	4.75 мм	MNS AASHTO T88 : 2014	%	95-100	79.4
6	2.36 мм	MNS AASHTO T88 : 2014	%	80-100	63.01
7	1.18 мм	MNS AASHTO T88 : 2014	%	50-85	45.11
8	0.600 мм	MNS AASHTO T88 : 2014	%	25-60	31.98
9	0.425 мм	MNS AASHTO T88 : 2014	%		25.09
10	0.300 мм	MNS AASHTO T88 : 2014	%	10-30	18.74
11	0.150 мм	MNS AASHTO T88 : 2014	%	2-10	9.00
12	0.075 мм	MNS AASHTO T88 : 2014	%		5.45
13	Асгаасан нягт	MNS 2916:2014	г/см ³		1.627
14	Ширхэгийн дундаж нягт	MNS 2916:2014	г/см ³	>2.4	2.574
15	Тоос шаварлагийн хэмжээ	MNS 2916:2014	%	<3	7.54
16	Ширхэглэлийн модуль	MNS ASTM C 88:2004	г	2.1-3.1	2.96
17	Ширхэг хоорондын зай	MNS 2916:2014	%		36.80
18	Хайргархаг хэсгийн агууламж	MNS 2916:2014	%	<5	20.61

Лабораторийн үр дүнгээс үзвэл тухайн элс нь байгалийн элс нь тоос шаврын агууламжаараа техникийн шаардлага хангахгүй байна. /Шинжилгээний үр дүнг тайланд хавсаргав/.

V. ТОВЧ ДҮГНЭЛТ

1. Төлөвлөж буй трассын талбай нь инженер-геологийн төвөгшлийн ангиллаар дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй.
2. Судалгааны талбайн цаг уурын нөхцөлийг Монгол улсын Барилгын норм ба дүрэм “Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004-д заасны дагуу тодорхойлов.
3. Судлагдсан талбайд 1,0-10,0 метрийн гүнтэй 36 цооног өрөмдөхөд хөрсний ус болон олон жилийн цэвдэг хөрс илрээгүй. /2022 оны 3-р сарын байдлаар/
4. Талбайд өрөмдлөгөөр илэрсэн ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНБД50-103-21-ээр тодорхойлж хүснэгт V-1-д нэгтгэн үзүүлээ.

Хүснэгт V-1

ИГЭ-ийн дугаар	Хөрсний төрөл	Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа	Тооцооны эсэргүүцэл, кПа
		норматив	тооцооны		норматив	тооцооны			
			C ^н	C ^I		C ^{II}	φ ^н		
ИГЭ-1	Хайргархаг элс	2	1,3	2	43	38,7	43	50	500
ИГЭ-2	Элсээр чигжигдсэн хайрга	2	1,3	2	43	38,7	43	50	600
ИГЭ-3	Хайргархаг элсэнцэр	21	14	21	30	26	30	32	300
ИГЭ-4	Элсэнцэрээр чигжигдсэн хайрга	17	11,3	17	44	38	44	42,5	450
ИГЭ-5	Хайрга агуулсан шавранцар	37	24,6	37	25	21,7	25	27	250
ИГЭ-6	Хайргархаг шавранцар	47	31,3	47	26	22,6	26	34	350
ИГЭ-7	Жижиг ширхэгтэй элс	6	4	6	38	34,2	38	48	300
ИГЭ-8	Том ширхэгтэй элс	2	1,3	2	43	38,7	43	50	500
ИГЭ-9	Шавранцараар чигжигдсэн хайрга	25	16,6	25	41	35,6	41	40	450
ИГЭ-10	Өгөршлийн бүс/Шавранцараар чигжигдсэн хайрга/	14,5	9,6	14,5	32	27,8	32	37,5	500

5. Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН.01.01-2004–н дагуу ул хөрсний механик шинж чанарын норматив тооцооны үзүүлэлтүүдийг хүснэгтэд үзүүлэв

Хүснэгт V-2

ИГЭ-ийн дугаар	Хөрсний нэр төрөл	Автозамын ажлын үед ашиглагдах хөрсний ангилал /27-р хүснэгт/	Замын холбоослог ул хөрсний тооцооний үзүүлэлтүүд /20-р хүснэгт/			Хөрсний хөдөлтийн норматив гүн /46-р хүснэгт/	Хөлдөх үеийн овойлтын /31-р хүснэгт/		
			Ехөрс МПа	Фхөрс град	Схөрс МПа		ИВ	Хөрсний бүлэг	Овойлтын зэрэг
ИГЭ-1	Хайргархаг элс	Хайргархаг том ширхэглэлтэй элс	130	42	0,005	3,2	I	Овойлтгүй	≤1

ИГЭ-2	Элсээр чигжигдсэн хайрга	Хайргархаг том ширхэглэлтэй элс	130	42	0,005	3.5	I	Овойлтгүй	≤1
ИГЭ-3	Хайргархаг элсэнцэр	Тоосорхог элсэнцэр	108	32	0,045	3.0	IV	Хүчтэй овойлттой	7-10
ИГЭ-4	Элсэнцэрээр чигжигдсэн хайрга	Хөнгөн том элсэнцэр	65	40	0,005	3.5	II	Сул овойлттой	1-4
ИГЭ-5	Хайрга агуулсан шавранцар	Хөнгөн шавранцар	108	32	0,045	2.5	III	Овойлттой	4-7
ИГЭ-6	Хайргархаг шавранцар	Хөнгөн тоосорхог шавранцар	108	32	0,045	2.5	V	Хэтэрхий овойлттой	>10
ИГЭ-7	Жижиг ширхэгтэй элс	Нарийн ширхэглэлтэй элс	100	38	0,005	3.2	II	Сул овойлттой	1-4
ИГЭ-8	Том ширхэгтэй элс	Хайргархаг том ширхэглэлтэй элс	130	42	0,005	3.2	I	Овойлтгүй	≤1
ИГЭ-9	Шавранцараар чигжигдсэн хайрга	Хөнгөн шавранцар	108	32	0,045	3.5	III	Овойлттой	4-7
ИГЭ-10	Өгөршил /ШЧХ/	Хөнгөн шавранцар	108	32	0,045	3.5	III	Овойлттой	4-7

6. Улирлын хөлдөлтийн норматив гүн БНБД 23-01-09 /Дарви станцаар/:

- ИГЭ-1. Хайргархаг элсэн ул хөрсөнд: 3,21 м
- ИГЭ-2. Элсээр чигжигдсэн хайрган ул хөрсөнд: 3,57 м
- ИГЭ-3. Хайргархаг элсэнцэр ул хөрсөнд: 3,04 м
- ИГЭ-4. Элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрсөнд: 3,57 м
- ИГЭ-5. Хайрга агуулсан шавранцар ул хөрсөнд: 2,50 м
- ИГЭ-6. Хайргархаг шавранцар ул хөрсөнд: 2,50 м
- ИГЭ-7. Жижиг ширхэгтэй элсэн ул хөрсөнд: 3,04 м
